

БАТЛАВ:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГА Г.ЧИНЗОРИГ



/гарын үсэг/



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
Өргөн Нэвтрүүлгийн Зохицуулалтын Газар

“ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ  
ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ”  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

*Тендерийн дугаар: ХХЗХ/202401037*

*Багцын дугаар: Багц 3 - Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын хүрээнд телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгаанд хяналт, мониторинг хийх*

2024 он



## АГУУЛГА

1. Үндэслэл
2. Зорилго
3. Хяналт, мониторингийн хамрах хүрээ
4. Хяналт, мониторинг хийх үзүүлэлт
5. Хяналт, мониторинг хийхэд баримтлах зарчим
6. Тайлан
7. Ажлын даалгаврын шалгуур шаардлага
8. Хэрэгжүүлэх арга зүй ба ажлын хуваарь
9. Тайлан ирүүлэх удирдамж
10. Тайлангийн бүтэц, загвар

## 1. ҮНДЭСЛЭЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Сонгуулийн тухай хуулиар олгосон эрх үүргийн дагуу “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангуулж ажилладаг бөгөөд энэ хүрээнд 2012, 2016, 2020 оны УИХ-ын сонгууль, 2017, 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр радио, телевизээр дамжуулсан сонгуулийн сурталчилгаанд хяналт мониторинг хийж хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.22-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж 2024 оны ээлжит Монгол Улсын Их хурлын сонгуулийн сурталчилгааны хугацаанд телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаанд энэ хууль болон Сонгуулийн ерөнхий хорооноос батлан гаргах “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-д заасны дагуу хяналт, мониторинг хийж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

## 2. ЗОРИЛГО

Энэхүү ХХЗХ/202401037 тоот үйлчилгээний тендерийн “Багц-3” ажлын даалгаврын гол зорилго нь Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.22-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж энэ хууль болон “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-д заасан үзүүлэлтүүдээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий нийт телевизүүдийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж, тайлан мэдээг тухай бүр гаргаж, тайлан болон зөрчилтэй бичлэгийн жагсаалтыг өдөр бүр хүлээн авч шуурхай ажиллах шаардлагатай юм. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий бус телевизүүдийн хувьд сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх, сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй телевизүүдийн хувьд хууль, журамд заасан үзүүлэлт нэг бүрээр гаргасан тайлан мэдээнд үндэслэн зөрчлийг арилгуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч ажиллахад оршино.

Түүнчлэн сонгуулийн үеийн телевизийн хөтөлбөрт хяналт мониторинг хийснээр сонгуулийн сурталчилгааны талаарх мэдээлэл, судалгаа, статистик тоон мэдээлэл бүрдэх, сонгуулийн сурталчилгааны үйл явц, хуулийн хэрэгжилтийн талаар мэдээ, тайлан гаргах, энэ чиглэлээр судалгааны суурь бий болох юм. Тус хороо нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тайлан мэдээ гаргаж өгөхөөс гадна илэрсэн зөрчил дутагдал, журамд заасан чиглэлээр гомдол маргаан үүссэн тохиолдолд ашиглах эфирийн бичлэг, тайлан протоколын архив, сан үүсэх боломж бүрдэх юм.

### **3. ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ**

- 3.1. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль болон “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын дагуу тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй нийт телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 2 хоногийн өмнөөс санал авах ажиллагаа дуусталх хугацаанд хяналт, мониторинг хийнэ.
- 3.2. Хяналт, мониторингийн ажлыг өглөөний 06.00 цагаас шөнийн 01:00 цаг хүртэлх эфирийн цагт хийнэ. Шаардлагатай нөхцөлд хяналт, мониторингийн цагийг 1-2 цагаас илүүгүйгээр сунгаж болно.
- 3.3. Захиалагчийн зүгээс хяналт, мониторингид хамрагдах телевизүүдийн жагсаалт, шаардагдах мэдээллийг шалгарсан гүйцэтгэгчид гаргаж өгнө.
- 3.4. Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээт ажлын хугацаанд өөрийн хуулиар хүлээсэн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх үүднээс тухайн маргаантай холбоотой телевизүүдийн хөтөлбөрийн бичлэг авах, холбогдох мэдээллийг гаргуулж авах эрхтэй.

Захиалагч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын даалгаварт заасан хяналтын үзүүлэлтээр гарсан тайланг эрх бүхий холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж болно.

### **4. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТ**

- 4.1 Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль болон “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хуульд заасан сонгуулийн сурталчилгааны хугацаанд дараах үзүүлэлтийн дагуу хяналт, мониторинг хийнэ. “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам” эцэслэн батлагдсан тохиолдолд хяналт, мониторингийн үзүүлэлтэд өөрчлөлт гарч болзошгүй. Хяналт, мониторингийн үзүүлэлтүүд нь:
  1. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн протокол; Протокол нь телевизийн нэр, огноо, сурталчилгааны нэвтрүүлгийн нэр, эхэлсэн цаг, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа (цаг:мин:сек-ээр болон сек-ээр), эх сурвалж, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр зэрэг мэдээллийг агуулсан байна.
  2. Телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт 60 минутаас илүүгүй заалтыг хангасан байдал;
  3. Сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ноогдох шаардлагыг хангасан эсэх;
  4. Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 (таван) минутаас хэтрүүлэхгүй байх заалтын хэрэгжилтийн байдал;
  5. Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн

00:00 цагаас өмнө зогсоосон эсэх, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;

6. Сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт хуулиар тогтоосон 60 минут, 15 минутаас илүүгүй байх хугацааг зөрчсөн эсэх болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орсныг дамжуулсан, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн эсэх;
7. Сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш санал авах ажиллагаа дуустал хугацаанд болон ахин болон нэмэлт санал хураалт явуулах тохиолдолд дахин болон нэмэлт санал хураалт явуулж, сонгуулийн албан ёсны дүн зарлагдаж дуусах хугацаанд д сонгуулийн сурталчилгаа дамжуулсан эсэх;
8. Сонгуулийн сурталчилгааны эх сурвалжийг ил тод мэдээлсэн байдал. Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын доод хэсэгт сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна.
9. Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нийт нэр дэвшигчийг оролцуулсан байдал; Нэр дэвшигчдийн нэр, нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэрийг тодорхой илэрхийлсэн байна.
10. Улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулахгүй байх, хэрэгжилтийн байдал; (зөвхөн холбогдох эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу холбогдох дүн, мэдээг гаргах)
11. Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлсэн эсэх;
12. Нам, эвслийн дарга, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг хориглоно;
13. Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
14. Эрх бүхий байгууллагаас сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх олгосноос бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх, хэрэгжилт; (Захиалагчийн зүгээс сонгуулийн сурталчилгаа дамжуулах эрх бүхий телевизийн жагсаалтыг гаргаж өгнө)
15. Олон нийтийн радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны батлагдсан хуваарь, цагийн биелэлтэд мониторинг хийх, хэрэгжилтэд хяналт тавих; (Захиалагчийн зүгээс ОНРТ-ээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны батлагдсан хуваарь, цагийг гаргаж өгнө)

16. Олон нийтийн радио телевизээр нэвтрүүлэх улс, төрийн мэтгэлцээний нэвтрүүлгийн цагийн биелэлт, хөтөлбөрт нийт нам, эвсэл, нэр дэвшигчийг оролцуулсан байдал; Нэр дэвшигчдийн нэр, нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэрийг тодорхой илэрхийлсэн байна.
  17. Телевиз нь сонгуулийн сурталчилгаа, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл болон улс төрийн мэтгэлцээн бэлтгэн хүргэхдээ хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай гаргасан эсэх;
  18. Сонгуулийн сурталчилгаа хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай гаргасан эсэх;
- 4.2 Захиалагчаас шаардсаны дагуу холбогдох эфирийн дүрс, бичлэг, хөтөлбөрийн баримт, нотолгоог шуурхай гаргаж ирүүлнэ.
  - 4.3 Мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох үзүүлэлтээр нэмэлт мэдээ, тайланг боловсруулалт хийн түргэн шуурхай гаргах боломжтой байх.

## **5. ХЯНАЛТ, МОНИТОРИНГ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ**

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль болон "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам"-ийн дагуу радио, телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагыг баримтална.

### **5.1 Сонгуулийн сурталчилгааны протокол:**

- Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоосон эсэх, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн эсэх;
- Сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт хуулиар тогтоосон 60 минут, 15 минутаас илүүгүй байх хугацааг зөрчсөн эсэх болон сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвслийн дарга, нэр дэвшигчийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орсныг дамжуулсан, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн эсэх;
- Сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш санал авах ажиллагаа дуустал хугацаанд болон дахин болон нэмэлт санал хураалт дуустал хугацаанд сонгуулийн сурталчилгаа болон сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах эсхүл сонгууль оролцогч нам, эвслийн дарга оролцсон сонгуулийн сурталчилгааны бус аливаа нэвтрүүлэг, түүнчлэн тэдгээрийн таних тэмдэг, нэр, зураг, дүрс бичлэгийг гаргасан нэвтрүүлэг нэвтрүүлсэн дамжуулсан эсэх;

### **5.2 Сонгуулийн сурталчилгааны хугацааг тооцохдоо:**

- Сонгуулийн сурталчилгааны эх сурвалжийг ил тод мэдээлсэн сурталчилгааны аливаа материалын доод хэсэгт сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна.
- Харин энд заасныг хангаагүй, сонгуулийн сурталчилгаа гэдгээ тодорхой илэрхийлээгүй, эх сурвалжийг дурдаагүй боловч сонгуулийн сурталчилгааны

болон сурталчилгааны бус дараах нэвтрүүлэг гаргасан бол сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамааруулж тооцно. Үүнд:

- нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах, эх сурвалжийг дурдаагүй төлбөрт, захиалгат нэвтрүүлэг, зар сурталчилгаа нэвтрүүлсэн бол;
  - эх сурвалжийг тодорхой дурдаагүй аливаа нэвтрүүлэгт улс төрийн нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон хуулиар зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлагад оролцсон бол;
  - сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаа зэрэгт нам, эвсэл, нэр дэвшигчийн оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлэхийг хориглоно.
- Сонгуулийн талаарх дараах нэвтрүүлэг, сурталчилгаа нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй болно. Үүнд:
    - нам, эвсэл, нэр дэвшигчид болон сонгуулийн үйл явцын тухай радио, телевизийн өөрийн редакцын бэлтгэсэн мэдээ, сурвалжилга, тойм;
    - сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, сурталчилгаа;
    - улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг;
    - сонгуулийн хороодын албан ёсны мэдээ.

5.3 Нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 (таван) минутаас хэтрүүлэхгүй байх заалтын хугацааг тооцохдоо:

- Мэдээний хоногт гарах таван минутын хугацааг мэдээний нэвтрүүлэгч тухайн мэдээг танилцуулж эхэлсэн хугацаанаас эхлэн тооцно.
- Радио, телевизийн редакцид бэлтгэгдээгүй, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээ, нэвтрүүлгийг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулна.
- Мэдээллийн хөтөлбөр дундуур дамжуулж буй сонгуулийн сурталчилгааны бус цаг үе үйл явдлын шинжтэй сурвалжлага, мэдээгээр нэр дэвшигчийн эрхэлж байгаа ажил үүрэгтэй холбоотой мэдээ, сурвалжлага гарах, мэдээ, сурвалжлага дундуур тухайн нэр дэвшигч тусгайлан яриа өгсөн бол сэдвээс үл хамаарч зөвхөн нэр дэвшигчийн яриа өгсөн цагийг тухайн нэр дэвшигчид оногдох мэдээний 5 минутад хамааруулж тооцно.

5.4 Эрх бүхий байгууллагаас сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх олгосноос бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн эсэх, хэрэгжилт;

- Захиалагчийн зүгээс сонгуулийн сурталчилгаа дамжуулах эрх бүхий телевизийн жагсаалтыг гүйцэтгэгчид гаргаж өгнө.
- Радио, телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч болон түүний компанийн нэгдэл нь хэд хэдэн радио, телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол тэдгээрийн зөвхөн нэг радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлнэ.
- Хүүхэд, теле-худалдааны төрөлжсөн болон төлбөртэй радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байна.

## 6. ТАЙЛАН



- 6.1 “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын дагуу хуулиар тогтоосон сонгуулийн сурталчилгааны хугацаанд мониторингийн дүн, тайлан мэдээг ирүүлнэ. Нэгдсэн дүн форматын дагуу боловсруулж ирүүлнэ. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой тайлан, датаг Улаанбаатар хотын телевизийн хувьд хөтөлбөр дамжуулсан өдрөөс хойш 2 хоногийн дотор, орон нутгийн телевизийн хувьд бичлэг хөрвүүлснээс хойш 2 хоногийн дотор тус тус гаргаж захиалагчид нийлүүлнэ. Орон нутгийн телевизийн хөтөлбөрийн бичлэгийг хөрвүүлэх хугацаа нь тухайн бичлэгийн формат, чанар, бичлэг хүлээн авах шийдлээс хамаарах тул урьдчилан тодорхойлох боломжгүй байна. Тайлан ирүүлэх хугацааны нарийвчилсан хуваарийг нэмэлтээр сонгуулийн сурталчилгааны хяналт эхлэхээс 1 сарын өмнө 2 тал тохиролцоно.
- 6.2 Хяналт, мониторинг хийгдсэн хугацааны эфирийн 06:00-01:00 цагийн /хөтөлбөрийн/ өдөр бүрийн дэлгэрэнгүй протокол, дэлгэрэнгүй протоколд тухайн нэвтрүүлэг эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн нэр, төрөл жанр, тайлбар зэрэг бүх л мэдээллийг агуулсан байна;
- 6.3 Мониторингийн сар бүрийн дүн, үзүүлэлтийг програмын тусламжтай форматын дагуу автоматаар инфографик, график, чарт хэлбэрт оруулан ирүүлнэ.
- 6.4 Үүссэн гомдол маргааныг шийдвэрлэх зорилгоор тухайн телевизийн эфирийн бичлэгээс холбогдох нэвтрүүлгийн тодорхой цагийн бичлэг нийлүүлэх;
- 6.5 Тодорхой хугацаны дараа бичлэг устахаас өмнө Захиалагчид энэ талаар албажуулан албан тоотоор мэдэгдэж саналыг нь авсан байна.

## **7. АЖЛЫН ДААЛГАВРЫН ШАЛГУУР, ШААРДЛАГА**

### **7.1 Ерөнхий шаардлага**

- Гүйцэтгэгч болон хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд хамрагдаж байгаа этгээд нь компанийн тухай хуулийн 6.14-т заасан /нэг/ нэгдлийн оролцогчид биш байна.
- Гүйцэтгэгч нь хорооноос олгодог өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч бус байх, гүйцэтгэх удирдлагын хувьд сүүлийн 3 жил аль нэг телевизийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх удирдлагаар ажиллаагүй байна.

### **7.2 Техник, программ хангамж, ажлын туршлага, хүний нөөцийн чадавхи, санхүүгийн хувьд тавигдах шалгуур**

Энэхүү ажил нь телевизүүдийн Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийн бүртгэх, бүртгэхээс татгалзах журам”-ын шаардлагын биелэлтэд хяналт, мониторинг хийж, илэрсэн зөрчил дутагдлын дагуу хууль, журамд заасан арга хэмжээ авах үндэслэл болох бөгөөд арга хэмжээнд зөрчлийн талаар мэдэгдэх, сануулга өгөх, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжих эрхийг гурван сар

хүртэл хугацаагаар хязгаарлах хүртэл арга хэмжээ хамаарах тул хянуур нямбай ажиллаж, үнэн зөв алдаагүй тайлан гаргах, эфирийн дэлгэрэнгүй протокол, тайлан зөрүүгүй байх талаар анхаарч ажиллана.

Энэхүү ажлын даалгаврыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гэрээлэгч нь дараах нөөц боломж, чадвар, мэдлэг, туршлагыг хангах боломжтой байна. Үүнд:

- Ажлын даалгаврын хамрах хүрээнд заасан тооны телевизийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийх техникийн болон ажиллах хүчний чадавхийг бүрдүүлэх боломжтой байх;
- Дээрх тооны телевизүүдийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийх, эфирийн бичлэг хийх, хадгалах бүрэн хүчин чадал бүхий сервер, архивын техник төхөөрөмж, систем, шийдлийг бүрдүүлэх боломжтой байх;
- Хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд мониторингд хамрагдсан бүх телевизийн эфирийн бичлэгийг 3 сар хадгалах серверийн тоног төхөөрөмж, шийдлийг бүрдүүлэх боломжтой байх;
- Жагсаалтад хамрагдсан телевизийн сигналыг хүлээн авах техникийн шийдэл, нөөц шийдэл, ОСДҮЭ-ээс сигнал хүлээн авч байгаа тохиолдолд аль болох олон ОСДҮЭ-ийн сигналыг хүлээн авах боломжтой байх;
- Цахилгааны доголдолоос хамааралгүйгээр хяналт, мониторинг хийх, эфирийг найдвартай тасралтгүй бичих, хэвийн ажиллагааг цахилгааны хангах нөөц станц зэрэг шийдлийг бүрдүүлэх боломжтой байх;
- Дата мэдээллийн сангаас шаардлагатай тохиолдолд холбогдох харьцуулалт, судалгаа, дүн, мэдээ, тайланг, эфирийн бичлэгийг тухайн сар, өдөр, цаг минутаар түргэн шуурхай гаргах техник, технологи, програм хангамжийн боломжийг бүрдүүлэх, хөгжүүлэх боломжтой байх;
- Хяналт, мониторингийн үйлчилгээг хийх аргачлал, хяналт, мониторингийн ажлын төлөвлөлт, ажил үүргийн хуваарийг гаргах, хяналт, мониторингийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах чадавхитай байх;
- Гүйцэтгэгчийн ирүүлэх санхүүгийн санал нь өртөгт суурилсан байх бөгөөд санхүүгийн саналын үндэслэл, тооцоог дэлгэрэнгүй байдлаар гаргаж тайлбартай ирүүлнэ. Мониторингийн ажлын төлөвлөлт, ажил үүргийн хуваарийн дагуу нэг ажилтанд ногдох эфирийн цаг, телевизийн тоо, мониторингийн үзүүлэлт, тухайн ажилтны ажил үүрэгт Захиалагчийн ажлын эзлэх хувь, хэмжээ, ажлын ачаалал, зардлын тооцоо, төсвийг гаргаж үндэслэсэн байх;
- Датабааз, файлын сан, програм хангамж, мэдээллийг цахим халдлагаас хамгаалах мэдээллийн аюулгүй байдлыг хангасан системийн шийдлийг бүрдүүлэх боломжтой байх;
- Урьдчилгаа төлбөр авалгүйгээр “Ажлын даалгавар”-т тусгасан ажлыг хэрэгжүүлэх санхүүгийн чадамжтай байх;

Гүйцэтгэгч нь хамгийн багадаа дараах хүснэгтэд тусгасан шаардлагатай мэдлэг чадвар, туршлагатай боловсон хүчнээс бүрдсэн баг санал болгох ба гэрээнд заасан ажил үүргийг заасан хугацаанд гүйцэтгэх чадвартай байна.

Албан тушаал	Чиг үүрэг	Ажлын туршлага
--------------	-----------	----------------

Багийн ахлагч	Ажлыг удирдан зохион байгуулах, гэрээлэгчийг төлөөлж захиалагчтай харилцах	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны ажил, төсөл, багийн ажиллагаанд оролцож ажиллаж байсан туршлагатай байх</li> <li>• Судалгаа, шинжилгээ, статистик буюу холбогдох чиглэлээр зэрэг цолтой бол давуу тал болно</li> </ul>
Хяналтын ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээний бүтэц, загварыг боловсруулах, хяналт, мониторингийн явцад хяналт тавих	<ul style="list-style-type: none"> <li>• Статистик , судалгаа шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай</li> <li>• Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай</li> <li>• Мэдээ, тайланг алдаагүй, нягт нямбай гаргах чадвартай</li> </ul>
Програм хангамж хариуцсан ажилтан	Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх	<ul style="list-style-type: none"> <li>• Програм хангамжийн чиглэлээр ажилласан туршлагатай байх</li> <li>• Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх</li> <li>• Програм хангамж боловсруулах, хөгжүүлэлт хийх чадвартай байх</li> </ul>
Техник, ашиглалт хариуцсан ажилтан	Техникийн бүрэн бүтэн байдал, серверийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлээрээ л ажилласан туршлагатай байх</li> <li>• Хяналт, мониторингийн ажлын талаар мэдлэг, туршлагатай байх</li> <li>• Техник төхөөрөмжийн шинэчлэлт хийх, ашиглалт үйлчилгээг хийх, техникийн өргөтгөл хийх чадвартай байх</li> <li>• Техникийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах чадвартай байх</li> </ul>
Статистик судалгааны ажилтан	Хяналт, мониторингийн тайлан мэдээнд анализ, шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>• Статистик , судалгаа шинжилгээний чиглэлээр боловсрол эзэмшсэн</li> <li>• Дээд боловсролтой</li> <li>• Судалгаа шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах чадвартай байх</li> </ul>
Мониторингийн ажилтан	Бүртгэл хийх, тайлан бэлдэх	<ul style="list-style-type: none"> <li>• Их хэмжээний мэдээллийн баазтай ажиллах чадвартай</li> </ul>

## 8. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ БА АЖЛЫН ХУВААРЬ

Гүйцэтгэгч нь энэхүү ажлын даалгаврын хүрээнд хөтөлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах арга зүй, үйл ажиллагааны хуваарийг боловсруулна. Энэхүү үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөө болон үүнтэй ижил төстэй даалгаврыг ямар хугацаа, техникийн туслалцаа, ажлын бүтэц бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байсан туршлагын баримтжуулалтыг хавсаргавал зохино.

## 9. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ УДИРДАМЖ

Захиалагч тал гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд тайлангийн төрөл, тайлангийн төрлүүдийг ямар хугацаагаар авах тухайгаа тодорхой тусгана.

Гүйцэтгэгч нь тайлангийн бүтэц, аргачлалын дагуу тайланг нэгтгэж, дүгнэлт гаргахад ойлгомжтой, ирүүлсэн тайлан, мэдээг шууд ашиглах боломжтой, дахин боловсруулалт хийх шаардлагагүй, хялбар байдлаар ирүүлнэ.

#### 9.1 Тайлан гаргах хугацааны хуваарь, хүргүүлэх хэлбэр

- Улаанбаатар хотын телевизүүдийн сонгуулийн сурталчилгааны мониторинг, тайланг энэхүү ажлын даалгаврын 6.1-д заасан хугацаанд электрон хэлбэрээр захиалагч талд хүлээлгэн өгнө.
- Орон нутгийн телевизийн хөтөлбөрийн бичлэгийг хөрвүүлэх хугацаа нь тухайн бичлэгийн формат, чанар, бичлэг хүлээн авах шийдэл зэргээс хамаарч хугацаанд өөрчлөлт орж болохыг үгүйсгэхгүй. Тайлан ирүүлэх хугацааны нарийвчилсан хуваарийг нэмэлтээр сонгуулийн сурталчилгааны хяналт эхлэхээс 1 сарын өмнө 2 тал тохиролцоно.
- Сонгуулийн сурталчилгааны тайланг 7 хоногоор болон сонгуулийн нийт хугацааны тайланг тайлан тус бүрээр нэгтгэн ирүүлнэ.
- Нийт тайланг CD-д бичиж баталгаажуулан захиалагчид нэхэмжлэхийн хамт ирүүлнэ.

### 10. МОНИТОРИНГИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ /ЗАГВАР/

1. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн протокол; Протокол нь телевизийн нэр, огноо, сурталчилгааны нэвтрүүлгийн нэр, эхэлсэн цаг, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа (цаг:мин:сек-ээр болон сек-ээр), эх сурвалж, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, дохионы хэл, бичгэн тайлбартай эсэх зэрэг мэдээллийг агуулсан байх.

2. Телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт 60 минутаас илүүгүй заалтыг эсэх тайлан - огноо, телевизийн нэр (сурталчилгаа дамжуулах эрхтэй эсэх), дэх сурвалжаа тодорхой дурдсан эсэх, “төлбөртэй” эсвэл “захиалгатай” нэвтрүүлэг болон рекламны хугацаа, эх сурвалжаа дурдаагүй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, зөрчилтэй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, нийт хугацаа, 60 минутаас хэтэрсэн хугацаа, дохионы хэл, бичгэн тайлбартай эсэх зэрэг мэдээллийг агуулсан байх.

3. Сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвслээс нэр дэвшигчдэд ногдож байгаа эсэх, шаардлага хангасан эсэх тайлан - огноо, телевизийн нэр (сурталчилгаа дамжуулах эрхтэй эсэх), дэх сурвалжаа тодорхой дурдсан эсэх, “төлбөртэй” эсвэл “захиалгатай” нэвтрүүлэг болон рекламны хугацаа, эх сурвалжаа дурдаагүй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, зөрчилтэй нэвтрүүлэг болон рекламны хугацаа, нийт хугацаа, 15 минутаас хэтэрсэн хугацаа зэргийн агуулсан байх.

4. Телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 (таван) минутаас хэтрүүлсэн эсэх тайлан - огноо, телевизийн нэр, мэдээллийн хөтөлбөрийн нэр, эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, секундээр, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн мэдээний эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, дохионы хэл, бичгэн тайлбартай гарсан эсэх зэрэг мэдээллийг агуулсан байх.

5. Олон нийтийн радио, телевизээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны батлагдсан хуваарь, цагийн биелэлтэд мониторинг хийх, хэрэгжилтийн тайлан - огноо, нэвтрүүлгийн нэр, эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, нэвтрүүлгийн хэлбэр, цагийн хуваариар гарсан эсэх зэрэг мэдээллийг агуулсан байх.

6. Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлгийн тайлан - огноо, телевизийн нэр, нэвтрүүлгийн нэр, эхэлсэн, дууссан, үргэлжилсэн хугацаа, хөтөлбөрт нийт нэр дэвшигчийг оролцуулсан, оролцогчдийн нэр, дохионы хэл, бичгэн тайлбартай гарсан эсэх зэрэг мэдээллийг агуулсан байх.

7. Телевиз нь сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгийн тайлан - огноо, телевизийн нэр, нэвтрүүлгийн нэр, эхэлсэн, дууссан цаг, үргэлжилсэн хугацаа, дохионы хэл, бичгэн тайлбартай гарсан эсэх зэрэг мэдээллийг агуулсан байх.



**БАГЦ 3****Улаанбаатар хотын Өргөн нэвтрүүлгийн телевизийн жагсаалт**

<b>№</b>	<b>Эзэмшигчийн нэр</b>	<b>Телевизийн нэр</b>	<b>Хамрах хүрээ</b>
1.	АЭ энд Жааг ХХК	25-р суваг	Монгол Улс
2.	Улаанбаатар телевиз ХХК	UBS	Монгол Улс
3.	Гэгээн далай ХХК	TB5	Монгол Улс
4.	Алсын гэрэл ХХК	TM	Монгол Улс
5.	Супервижн медиа групп ХХК	SBN	Монгол Улс
6.	Суваг ти ви найм ХХК	TV8	Монгол Улс
7.	Чаннел-Уан ХХК	C1	Монгол Улс
8.	Медиа холдинг ХХК	TB9	Монгол Улс
9.	Тэнгэрлэг эх орон ХХК	Central	Монгол Улс
10.	Эн Ти Ви Бродкастинг ХХК	NTV	Монгол Улс
11.	Ийгл Бродкастинг ХХК	Eagle News	Монгол Улс
12.	Монгол телевиз ХХК	Монгол	Монгол Улс
13.	Про медиа нетворк ХХК	TenGer	Монгол Улс
14.	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	Star	Монгол Улс
15.	Имерж медиа ХХК	ETV	Монгол Улс
16.	Медиа боловсрол суваг ХХК	суваг	Монгол Улс
17.	Малчин удмын хийморь ХХК	Малчин	Монгол Улс
18.	Улс сүлд ХХК	Сүлд	Монгол Улс
19.	Фило ХХК	TV24	Монгол улс
20.	ТВ дөрөв ХХК	TV4	Монгол улс
21.	Датуком ХХК	BBS TV	Монгол улс

**Улаанбаатар хотын Арилжааны телевизийн жагсаалт**

<b>№</b>	<b>Эзэмшигчийн нэр</b>	<b>Телевизийн нэр</b>	<b>Хамрах хүрээ</b>
1.	Мөрөөдлийн суваг ТББ	Dream tv	Монгол Улс
2.	Шууд Ти Ви ХХК	Asar shop	Монгол Улс
3.	Парламентын суваг ХХК	Парламентын суваг	Монгол Улс
4.	Эх гоёот медиа групп ХХК	Channel 11	Монгол Улс

5.	Медиа холдинг ХХК	Синема	Монгол Улс
6.	Өлзий медиа ХХК	Өлзий телевиз	Монгол Улс
7.	Эм Ви Эс ХХК	Мон плас	Улаанбаатар хот
8.	Эйшн бокс ХХК	Asian box	Монгол Улс
9.	Гэгээн далай ХХК	TB5-2	Монгол Улс
10.	Мөүвибокс ХХК	Movie Box	Монгол Улс
11.	Форчун глобал ХХК	Аист Глобал	Монгол Улс
12.	Эн Би Жи Кинг Монголиа ХХК	Нийслэл	Монгол Улс
13.	Эвергрийнлайф ХХК	7-р суваг	Монгол Улс
14.	Эс Си Эйч ХХК	Суваг 1	Монгол Улс
15.	Хатрек ХХК	Eco tv	Монгол Улс
16.	Ханлиг Өлзий ХХК	Скай	Улаанбаатар хот
17.	Модерн Кастл Модифаер ХХК	Соён гэгээрүүлэгч	Монгол Улс
18.	Нэйшнл ньус корпорэйшн ХХК	Bloomberg	Монгол Улс
19.	Ди Ви Продакшн ХХК	TV3	Монгол Улс
20.	Монголиан ньус чаннел ХХК	MNC	Монгол Улс
21.	Гэгээн далай ХХК	Moviemax	Монгол Улс
22.	Дэлхийн чимээ медиа групп ХХК	Live	Монгол Улс
23.	Реал Мастер линкс ХХК	Like	Монгол Улс
24.	Монгол телевиз ХХК	Монгол тв +1	Монгол Улс
25.	Хөгжил телевиз ХХК	Хөгжил	Монгол Улс
26.	Малчин телевиз ХХК	Мянгат малчин	Монгол Улс
27.	Дөрөв кэй мүүв ХХК	Талын Монгол	Монгол Улс
28.	Эн Ти Эн Эйч Ди Медиа Групп ХХК	NTN	Монгол Улс
29.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 1	Монгол Улс
30.	Мюзик бокс ХХК	Хөг-жим	Монгол Улс
31.	Эгон ХХК	ШОП Монголиа	Монгол Улс
32.	Масс Ти Ви ХХК	Масс ТВ	Монгол Улс
33.	Монзах ХХК	ONTV	Монгол Улс
34.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 2	Монгол Улс
35.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 3	Монгол Улс



36.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 4	Монгол Улс
37.	Премьер спортс нэтворк ХХК	Premier 5	Монгол Улс
38.	Сарны чулуу анар ХХК	TV6	Улаанбаатар хот
39.	Маст технологи ХХК	News channel	Улаанбаатар хот
40.	Буган соёл ХХК	Хөх Монгол	Улаанбаатар хот
41.	Энтертайнмент интэрпрайс ХХК	Бидний цөөхөн Монголчууд	Монгол улс
42.	Лакс ТВ Монгол ХХК	Luxe TV	Улаанбаатар хот
43.	Найс ти ви ХХК	АВТО	Улаанбаатар хот
44.	Сичаннель ХХК	Си чаннель	Улаанбаатар хот
45.	Малчин удмын хийморь ХХК	Их засаг	Монгол Улс
46.	Монвсат нэтворк ХХК	Нэгдэл	Улаанбаатар хот
47.	Жи суваг ХХК	Gandan TV	Монгол улс
48.	Эм Ди Энтертэйнмент ХХК	TV2	Монгол улс
49.	Төгс барчин хангай ХХК	Цахим монгол ТВ	Улаанбаатар хот
50.	Трионикс мета вишн ХХК	Попкорн тв	Улаанбаатар хот
51.	Хит-Интертаймент ХХК	НIT	Улаанбаатар хот
52.	Эм Эн Медиа Групп ХХК	MNTV	Улаанбаатар хот
53.	Гангын урсгал ХХК	GU телевиз	Улаанбаатар хот
54.	Байсикл медиа ХХК	BMTV	Улаанбаатар хот

**Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн жагсаалт**

№	Эзэмшигчийн нэр	Телевизийн нэр	Хамрах хүрээ
1.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-1	Монгол улс

2.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-мэдээ	Монгол улс
3.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-спорт	Монгол улс
4.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-World	Монгол улс
5.	Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз	MNB-хүүхэд, гэр бүл	Монгол улс

### Төлбөртэй телевизийн жагсаалт

№	Эзэмшигчийн нэр	Телевизийн нэр	Хамрах хүрээ
1.	Контент дистрибьюшн ХХК	UniSport 1	Монгол улс
2.	Контент дистрибьюшн ХХК	UniSport 2	Монгол улс
3.	Номадиа нэтворк ХХК	Монгол кино	Монгол улс
4.	Номадиа нэтворк ХХК	Монгол цуврал	Монгол улс
5.	Номадиа нэтворк ХХК	Шинэ кино	Монгол улс
6.	Монвсат нэтворк ХХК	Төлбөрт үзэлт 900	Монгол улс
7.	Монвсат нэтворк ХХК	Шилдэг кино 996	Монгол улс
8.	Монвсат нэтворк ХХК	Монгол кино 997	Монгол улс
9.	Монвсат нэтворк ХХК	Ази кино 998	Монгол улс
10.	Монвсат нэтворк ХХК	Тв театр 999	Монгол улс
11.	Маст технологи ХХК	900 Кино	Монгол улс
12.	Маст технологи ХХК	902 Kids	Монгол улс
13.	Маст технологи ХХК	903 HITS	Монгол улс
14.	Скайтел ХХК	MN+	Монгол улс
15.	Номадиа нэтворк ХХК	DDISHMUSIC	Монгол улс
16.	Монвсат нэтворк ХХК	ТВ театр 995	Монгол улс
17.	Скайтел ХХК	Sky live	Монгол улс
18.	Номадиа нэтворк ХХК	Ddsih live	Монгол улс
19.	Юпланэт ХХК	Юнилайв 88	Монгол улс
20.	Монвсат нэтворк ХХК	Тв театр 994	Монгол улс
21.	Меүви бокс плас ХХК	Moviebox Plus	Монгол улс

**Орон нутгийн Өргөн нэвтрүүлгийн жагсаалт**

<b>№</b>	<b>Эзэмшигчийн нэр</b>	<b>Телевизийн нэр</b>	<b>Хамрах хүрээ</b>
1.	Ар Би Эм Ти ХХК	АВ ТВ	Архангай аймаг
2.	Мичид Ньюс ХХК	Тамир ТВ	Архангай аймаг
3.	Эм Юу Ти Эй ХХК	Саян ТВ	Баян-Өлгий аймаг
4.	Сайхан Монгол ЭИАК ТББ	Сайхан Монгол ТВ	Булган аймаг
5.	МТД ХХК	Номгон ТВ	Баянхонгор аймаг
6.	Өлзийтийн хийморь өөдөө ХХК	Баянхонгор ТВ	Баянхонгор аймаг
7.	Ногоон замын эхлэл ХХК	Алтай телевиз	Говь-Алтай аймаг
8.	Дархан мэдээлэл төв ХХК	DBS TV	Дархан-Уул аймаг
9.	Ай Жи Би Ти Виз ХХК	RGB TV	Дархан-Уул аймаг
10.	Ди медиа агентлаг ХХК	DTV	Дорноговь аймаг
11.	Ашдын нөхөр ХХК	Дорнод ТВ	Дорнод аймаг
12.	Гэгээн гэгээ ХХК	Мижи ТВ	Дорнод аймаг
13.	Шинэ зураг ХХК	Жаран ТВ	Дорнод аймаг
14.	Дорнын Хэрлэн тал НҮТББ	Дорнын ТВ6	Дорнод аймаг
15.	Тамсаг мэнэнгийн тал ХХК	Талын анир ТВ	Дорнод аймаг
16.	Завхан толь сонин ХМХ	AIR1 ТВ	Завхан аймаг
17.	Номин Макс ХХК	New broadcasting Television	Орхон аймаг
18.	Ишилан ХХК	EBS TV	Орхон аймаг
19.	Эрдэнэт таймс сонин ХМХ	ETV	Орхон аймаг
20.	Очир роуд ХХК	Тусгал 1 ТВ	Орхон аймаг
21.	Асгатын гол ХХК	Мэдээллийн бирж	Орхон аймаг
22.	Бунадо ХХК	Тэнгэр ТВ	Орхон аймаг
23.	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	Эрдэнэт ТВ	Орхон аймаг
24.	Хас-Өрлөг ТББ	Хас ТВ	Өвөрхангай аймаг
25.	Түвдэнгийн Бор Интернэшнл ХХК	Алтан говь ТВ	Өмнөговь аймаг
26.	Ёл цуурай ХХК	Говь HD TV	Өмнөговь аймаг

27.	Говийн долгион мэдээллийн төв НҮТББ	Говийн наран ТВ	Өмнөговь аймаг
28.	Морьтын ширээ ХХК	SB TV	Сүхбаатар аймаг
29.	Миний Монгол Энтертаймэнт ХХК	Миний монгол	Сэлэнгэ аймаг
30.	Төв ньюс ХХК ТBS	TBS	Төв аймаг
31.	Очир Арвай төв ХХК	Төв ТВ	Төв аймаг
32.	Сама-Увс ХХК	Увс ТВ	Увс аймаг
33.	Хоса ТВ ХХК	MBC ТВ	Увс аймаг
34.	Огторгуйн асар нийтийн мэдээллийн төв НҮТББ	Ховд телевиз	Ховд аймаг
35.	Некст дэвшил ХХК	Олон ястны телевиз	Ховд аймаг
36.	Ойрад ТВ ХХК	Ойрад ТВ	Ховд аймаг
37.	Хөвсгөл мэдээллийн төв НҮТББ	Далай ээж ТВ	Хөвсгөл аймаг
38.	Өсөх прогресс ХХК	Хөвсгөл ТВ	Хөвсгөл аймаг
39.	Өндөрхаан цахим ертөнц НҮТББ	Өндөрхаан ТВ	Хөвсгөл аймаг
40.	Буян налайх ХХК	Буян телевиз	Улаанбаатар.Налайх дүүрэг
41.	Жудагмедиа пресс ХХК	Гэгээнтэн ТВ	Өвөрхангай аймаг
42.	Дадишуар гоёл ХХК	DSS ТВ	Дорноговь аймаг
43.	Эхлэх шинэ жаргалант ХХК	Жаргалант ТВ	Ховд аймаг
44.	Ийст юу би өү ХХК	D1ТВ	Дорнод аймаг
45.	Дербес ХХК Дербес ТВ	Дербес ТВ	Баян-Өлгий аймаг